

- Би бүх **нэмэлт ачаагаа** илгээсэн. Зөвшөөрөгдсөн ачааны хэмжээ, килограммыг миний захиалгын хуудсан дээр тодорхой заасан.
 - Би **ИОМ-ын гялгар уутаа** авсан бөгөөд хэрэв дамжин өнгөрөх эсвэл нисэх буудалд ирэх туслалцаанд шаардлагатай бол би үүнийг нүдэнд харагдахуйц ил авч явна.
 - Би өөрийнхөө болон тэжээлгэгч(д)ийнхээ хүчинтэй паспорт, яаралтай аяллын бүх бичиг баримтыг/Laissez Passez авсан: Laissez-Passer, үнэмлэх, паспорт г.м.
 - Миний гар тээшинд ямар ч **шингэн** (үүний дотор шингэн хоол хүнсний бүтээгдхүүн, гоо сайхны бараа), тос, түрхлэг байхгүй.
 - Би аяллынхаа явцад шаардагдах **тусгай хэрэгцээний** (хоол, эм, дугуйтай сандал, өвчин г.м.) талаар Зөвлөхдөө мэдээлсэн.
 - Жирэмсэн эмэгтэйчүүдэд:** Би **жирэмсэн эмэгтэйн** хувьд онгоцонд сууж болохыг тодорхойлж, жирэмслэлтийн хэдэн долоо хоногтойг заасан эмчийн магадлагаа авсан.
 - Би аяллын явцад шаардагдах **эм, эмчилгээг** бүрэн авсан бөгөөд эмчийн магадлагааны эхийг гар тээшиндээ хийсэн.
 - Би нислэгийн явцад хэрэглэхгүй бүх эмээ ачаанд өгсөн тээшиндээ хийсэн.
 - Харгалзан яваа хүнгүй насанд хүрээгүй хүн:** Би **харгалзан яваа хүнгүй насанд хүрээгүй хүний** хувьд эцэг эхийн болон хууль ёсны асран хамгаалагчийнхаа зөвшөөрөл зэрэг аялахад шаардагдах бүх бичиг баримтаа авсан.
- Зөвхөн хэрэв та эх орондоо эргэн очих тусламж авч байгаа ба ингэх эрхтэй бол үйлчилнэ:
- Би нисэхээс өмнөх зөвлөх уулзалт дээр Эх орондоо эргэн очих хүсэлтийн маягтад гарын үсэг зурсан.
 - Би нисэх буудлаас хөдөлмөгцөө Эх орондоо эргэн очих гэрээнд гарын үсэг зурна.
 - Би буцаж очсоныхоо дараа ч гэсэн эх хувийг хадгална.
 - Эх оронд буй ИОМ-ын офисын холбоо барих хүний мэдээлэл нь Эх орондоо эргэн очих гэрээн дээр байгаа гэдгийг би ойлгож байна.

Таны зөвлөх буюу нийгмийн туслагчийн санал бодол:

БУЦАГСДЫН АЯЛЛЫНГАРЫН АВЛАГА

Бельгисэ сайн дураар буцах



Towards a more integrated migration policy, made possible by the AMIF

fedasil
FEDERAL AGENCY FOR THE
RECEPTION OF ASYLUM SEEKERS



International Organization for Migration (IOM)
Organisation internationale pour les migrations (OIM)
Internationale Organisatie voor Migratie (IOM)

Та эх орон руугаа буцаж байна уу?

Орогнол эрэгчид буцах ба гарч явах


Та Олон улсын цагаачлалын байгууллагын (IOM) тусламжтай Бельгис сайн дураараа буцахаар өргөдөл гаргасан. Бид таны буцах бүх үе шатанд туслахаар бүхий л талаар хүчин чармайлт гаргаж байна.

Энэ мэдээллийн хуудсыг анхааралтай уншина уу.

Маргашийг бүтээхийн төлөө өнөөдөр буцах

Нисэх онгоцны буудал дээр (Брюсселийн үндэсний нисэх онгоцны буудал/Zaventem)

- Та саадгүй аяллаа баталгаажуулж, ямар нэгэн болзошгүй саатлаас зайлсхийхийн тулд ачаа тээшний тоо, жингийн зөвшөөрөгдсөн хэмжээг хатуу баримтлах ёстой.
- Таны уулзах цэг явахаас **3 цагийн өмнө** 6-р эгнээ.
- 6-р эгнээнд тантай IOM-ын нисэх онгоцны буудлын туслагчдын нэг уулзана. Тэд хөх өнгийн IOM-ын тэмдэгтэй хувцас, малгай өмссөн байгаа тул танихад амархан.



- IOM нисэх онгоцны буудлын туслагчдын нэг таны нисэх онгоцонд суухаас өмнөх ажиллагаанд тусална. Тухайлбал ачаа тээшийг тань өгөх, аюулгүй алба болон паспортын шалгалтаар ороход тань тусална.
- IOM нисэх онгоцны буудлын туслагч таныг онгоцонд суух хаалга хүртэл тань дагаж явж, тэнд таны онгоцонд суух тасалбарыг гардуулна.
- Та аяллынхаа туршид эцсийн нисэх онгоцны буудал хүртлээ аялахдаа IOM-ын ажилтнуудад амархан танигдахын тулд **IOM-ын уутыг** ашиглах ёстой.



Дамжин өнгөрөхдөө

- Хэрэв та шууд нислэггүй бол, Европын томоохон нисэх онгоцны буудлууд дээр IOM-ын ажилтан танд тусална.
- Хэрэв явахаасаа өмнө зөвшөөрсөн бол, боломжтой бол IOM таныг Европоос гадагш дамжин өнгөрөхөд туслана.
- Хэрэв та дамжин өнгөрөхдөө IOM-ын тусалцааг авч байгаа бол, IOM-ын уутыг байнга биедээ авч явах ёстой. Ингэснээр IOM-ын ажилтнууд таныг танихад улам амар болно.
- IOM таныг эсэн мэнд, цагтаа очуулахаар дамжих нислэгүүдийг зохицуулна.
- Хэрэв танд эмнэлгийн тусгай тусламж хэрэгтэй гэж таны өмгөөлөгч мэдэгдсэн бол, IOM аяллын компани, нисэх онгоцны буудлын үйлчилгээтэй хамтран зохих ёсны тусламж үзүүлнэ.
- Хэрэв дамжин өнгөрөх явцдаа өөр улс оронд хонох шаардлага гарвал, IOM танд байр олж өгч болно.

Очингуут

- Хэрэв та урьдчилан хүсч, тохирсон бол, очиход тань IOM угтан авч болно. IOM таныг танихад дөхөм болгохын тулд, IOM-ын уутыг байнга биедээ авч явах ёстой.
- IOM таныг хил нэвтрүүлэхэд шаардлагатай ажиллагаанд, үүний дотор гааль, цагаачлалын хяналтын ажиллагаанд тусална.
- Хэрэв танд эмнэлгийн тусгай тусламж хэрэгтэй бол, IOM газар дээрх үйлчилгээтэй (жишээ нь: түргэн тусламжийн тэрэг, эмч) хамтран зохих ёсны тусламж үзүүлнэ.



Гэртээ эсэн мэнд харихыг хүсэн ерөөе!

IOM Бельги, Люксембург

Rue Montoyerstraat 40

1000 Brussels

Утас: +32 (0) 2 287 70 00

Факс: +32 (0) 2 287 70 05

Имэйл: IOMBrusselsREAB@iom.int

Олон улсын цагаачлалын байгууллага

